

Хууль зүй, дотоод
хэргийн яам

Олон Улсын
санхүүгийн корпораци

**Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг
хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо
/захиалгат судалгаа/**

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

АГУУЛГА

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хоёр.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо:

- 2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.Нийт дүнг тооцож гаргах;
- 2.5.Хялбарчлах боломжийг шалгах

Гурав.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:

- 3.1.Төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;
- 3.2.Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- 3.3.Гарах зардлыг тооцох;
- 3.4.Зардлыг нэгтгэн тооцох;
- 3.5.Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

/Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл/

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан доорх зардлын тооцоог хийв.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, зардал, үр өгөөжийн харьцааг харгалзан зардлыг, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тооцооны зорилго оршино.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл нь Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга бөгөөд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин зохион байгуулах, татан буулгах замаар төлбөрийн чадваргүйдлийн хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар хуулийн төсөлд заасан байна.

Зардлын тооцоо хийх хамгийн эхний алхам нь хуулийн төсөлтэй танилцаж, хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох явдал бөгөөд уг хуулийн төсөл нь “шинэчилсэн найруулга” хэлбэрээр бичигдэж байгаа тул уг харилцаа нь нэгэнт хуулиар зохицуулагдсан байгааг харгалзан зөвхөн шинээр бий болж байгаа үүрэгтэй холбоотойгоор үүсэх зардлыг тооцоолох юм.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлаас Дампуурлын тухай хуулийг 1997 онд батлан гаргасан бөгөөд дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой механизм манай улсад нэгэнт бий болсон бөгөөд хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслөөр уг механизмд шинээр нэмэгдэж байгаа зохицуулалтаас иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад зардал үүсгэх үүрэг бий болгосон зохицуулалтын улмаас үүсэх зардлын тооцоог хийх юм.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг судалж үзэхэд дараах зохицуулалт нь иргэн болон төрийн байгууллагад зардал үүсгэхээр байна. Үүнд:

ИРГЭН:

“27 дугаар зүйл.Хэрэг гүйцэтгэгчид тавигдах шаардлага

27.1.Хэрэг гүйцэтгэгч нь энэ хуулийн 27.2-т заасан шалгуурыг хангасан хувь хүн, эсхүл хууль, санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий, энэ хуулийн 29.1-д заасан эрх авсан хуулийн этгээд байна.

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

27.2.Хэрэг гүйцэтгэгч хувь хүн дараах шалгуурыг хангасан байна:

27.2.1.хууль, санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэл, аудит, эсхүл бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан;

27.2.2.хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалтад хамрагдсан;

27.2.3.эрх зүйн чадамжтай;

27.2.4.ял шийтгэлгүй;

27.2.5.энэ хуулийн 29.1-д заасны дагуу эрх авсан.”

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА:

“29 дүгээр зүйл.Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох

29.1.Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх **эрхийг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 29.2-т заасан журмын дагуу олгоно.**

29.2.Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.

29.3.Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн нэрсийн жагсаалтыг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын **цахим сан болон шүүхийн мэдээллийн цахим санд байршуулна.”**

Хуулийн төсөл нь дээрх зохицуулалтаараа иргэн болон төрд шинэ үүргийг бий болгосон байх ба хуулийн этгээдэд үүсгэх зардал агуулаагүй байна. Иймд цаашид зардал тээгч дээрх хоёр бүлэг болох иргэн болон төрийн байгууллагын зардлыг нарийвчлан тооцоолох болно.

ХОЁР. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙДЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төсөл батлагдснаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо аргачлалд заасны дагуу дараах дарааллыг баримтлана. Үүнд:

- Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- Тоон үзүүлэлтийг тооцох;
- Нийт дүнг тооцож гаргах;
- Хялбарчлах боломжийг шалгах

Иргэний хувьд хууль тогтоомжид тусгагдсан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан шууд гарах мөнгөн зардлаас гадна уг үүргийг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг /ачаалал/ тооцдог болно.

2.1. ИРГЭНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

Энэ үе шатанд Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөлд шинээр тусгагдсан иргэний гүйцэтгэх үүргийг болон түүний мэдээллийн агуулгыг нэг бүрчлэн тодорхойлох юм. Хуулийн төсөлд зааснаар дараах үүргийг иргэн шинээр гүйцэтгэхээр заасан байна. Үүнд:

- Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн **27.2.2 дахь заалтад заасны дагуу “хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалтад хамрагдах”** үүрэг;
- Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу **“Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгох шалгалт өгөх”** үүрэг.
-

Дээр тодорхойлсон үүрэг тус бүрийг гүйцэтгэхэд иргэн ямар үйл ажиллагааг хийх шаардлагатай болохыг “мэдээллийн агуулга” гэсэн ойлголтоор илэрхийлэх юм. Мэдээллийн агуулга гэдэгт гүйцэтгэх үүрэг тухайн үүргийг хүлээж буй иргэнээс тодорхой мэдээллийг төрийн байгууллага болон гуравдагч этгээдэд бэлтгэж өгөх, бэлэн байлгах болон хүргүүлэхийг буюу хүсэлтэд хавсаргахаар хууль, журамд заасан баримт бичиг, мэдээллийн бүрдлийг хамруулан ойлгоно.

Мэдээллийн агуулгыг тогтоохдоо хуулийн төсөлд шууд заасан бол түүнийг үндэслэх, шууд нэрлэн заагаагүй бол бусад хууль тогтоомжоор гүйцэтгэж байгаа ижил төрлийн үүргээс жишээ авах байдлаар тогтоохыг аргачлалд заасан болно.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөлд иргэн шинээр гүйцэтгэх “хэрэг гүйцэтгэгч бэлтгэх сургалтад хамрагдах”, “хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт өгөх”-д иргэнээс бүрдүүлж өгөх ёстой баримт бичгийн бүрдлийг шууд зааж өгөөгүй бөгөөд харин хэрэг гүйцэтгэгчид тавигдах шаардлагыг тогтоож өгсөн болно. Иймд мэдээллийн агуулгыг бүрэн тогтоохын тулд хуулийн төсөл боловсруулагдаж байгаа энэ цаг хугацаанд бусад ижил төстэй үүргийг судлах замаар мэдээллийн агуулгыг тогтоох нь зүйтэй байна.

Хуулийн төслөөс харахад хэрэг гүйцэтгэгчийн эрхийг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор заасан байх тул уг салбарт олгож байгаа “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” болон “хуульчийн мэргэжлийн сургалтад хамрагдсан” байх үүргийг хүлээж байгаа иргэний уг үүргийг хэрэгжүүлэхэд бүрдүүлж байгаа баримт бичгийг дүйцүүлэх замаар мэдээллийн агуулгыг доорх байдлаар тодорхойлов.

Хүснэгт 1

д/д	Иргэний гүйцэтгэх үүрэг	Үүргийн агуулга	Тайлбар
-----	-------------------------	-----------------	---------

1	Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалтад заасны дагуу “хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалтад хамрагдах” үүрэг	Сургалтад хамрагдах хүсэлт бүхий өргөдөл	Иргэний өөрийн гаргасан хүсэлтийн дагуу сургалтад хамрагдах тул өргөдлийг мэдээллийн агуулгаар тооцов:
		Цаашид хэрэг гүйцэтгэгч хийх урьдчилсан нөхцөл буюу хуульд заасан мэргэжил эзэмшсэн болохыг нотлох баримт бичиг	Хуулийн төслийн 27.2.1-т хэрэг гүйцэтгэгч болох иргэн нь тодорхой мэргэжил эзэмшсэн байхыг шаардсан тул үүнийг мэдээллийн агуулгад тооцов.
		Сургалтын хураамж төлсөн баримт	Сургалт нь бусад эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтын нэгэн адил төлбөртэй байна гэж үзэж мэдээллийн агуулгаар тооцов.
2	Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу “Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгох шалгалт өгөх” үүрэг	Хууль, санхүү, нягтлан бодох бүртгэл, аудит, бизнесийн удирдлагын мэргэжил эзэмшсэнийг нотлох баримт бичгийн хуулбар	Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.1 дэх заалтад хэрэг гүйцэтгэгч болох хувь хүнд дээрх мэргэжилтэй байх шаардлага тавьсан тул үүнийг нотлох боловсролын баримт бичгийн хуулбар нь мэдээллийн агуулгад хамаарах юм. Түүнчлэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан мэргэжлийн шалгалтад оролцогчоос шаардаж буй баримт бичгийг харгалзаж байгаа болно.
		Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан болохыг тодорхойлох баримт бичиг	Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.1-д 3-аас доошгүй жил ажилласан байх шаардлага тавигдсан.
		Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалтад заасан сургалтад хамрагдсан болохыг нотлох баримт бичиг	Хуулийн төслийн 27.2.2-т сургалтад хамрагдсан байх шаардлага тавьсан тул мэдээллийн агуулгаар тооцов.
		Батлагдсан маягтын дагуу гаргасан өргөдөл	Бүх мэргэжлийн шалгалт нь оролцогчоос өргөдлөөр хүсэлт гаргахыг шаарддаг тул

			мэдээллийн агуулгаар тооцов.
		Шалгалтын хураамж төлсөн баримт	Бүх мэргэжлийн шалгалт нь тодорхой хэмжээний хураамжтай байдаг бөгөөд уг хураамжийг төлсөн баримтыг шалгалтад оролцогч нь зайлшгүй бүрдүүлж өгдөг тул мэдээллийн агуулгаар тооцов.

2.2.ЦАГ ХУГАЦАА БОЛОН ГАРЧ БОЛОХ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Энэ үе шатыг

1.Үүргийг гүйцэтгэхэд буюу үүргийн агуулга бүрийг бүрдүүлэхэд иргэний зүгээс хийгдэх стандарт ажиллагааг тогтоох;

2.Уг стандарт ажиллагаанд зарцуулах хугацааг тодорхойлох;

3.Иргэнээс шууд гарах зардлыг мөнгөн дүнгээр тооцоолох ажиллагаа хийх гэсэн 3 алхмаар гүйцэтгэх юм.

Өмнөх шатанд тодорхойлсон үүрэг, түүний агуулгыг холбогдох төрийн байгууллагад бүрдүүлж өгөхөд иргэний зарцуулах хугацааг тогтоохдоо уг үүрэг нь шинээр бий болж байгаа шууд ашиглах бэлэн статистик байхгүй тул хуульчийн мэргэжлийн шалгалт болон сургалтад хамрагдахад зарцуулж байгаа хугацааг судлах замаар гаргасан болно. Мөн Засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг дагалдан боловсруулсан гарын авлагад тусгагдсан Стандарт үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааны хүснэгтийг харгалзав.

Хүснэгт 2

д/д	Иргэний гүйцэтгэх үүрэг	Мэдээллийн агуулга буюу бүрдүүлэх баримт бичиг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
1	Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалтад заасны дагуу “хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалтад хамрагдах” үүрэг	Сургалтад хамрагдах хүсэлт бүхий өргөдөл	Өргөдлийн маягттай танилцаж, шаардлагатай мэдээллийг бэлтгэх	10 мин
			Өргөдлийг маягтын дагуу бөглөх	5 мин
			Бөглөсөн маягтын алдааг нягтлах	5 мин
		Цаашид хэрэг гүйцэтгэгч хийх урьдач нөхцөл буюу хуульд заасан мэргэжлийг эзэмшсэн болохыг нотлох баримт бичиг	Баримт бичгийг олшруулах	5 мин
			Баримт бичгийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэх	15 мин

		Сургалтын хураамж төлсөн баримт	Банкинд хандаж холбогдох дансанд хураамжийг төлөх	15 мин
			Хураамж төлсөн баримтыг өргөдөлд хавсаргах	5 мин
2	Нийт хугацаа			60 минут
3	Уг үүрэгтэй холбоотой иргэнээс шууд гарах мөнгөн зардал		Зардлын хэмжээ	
3.1.	Баримт бичиг нотариатаар гэрчлүүлэх зардал		2000 ²	
3.2.	Сургалтын төлбөр		тодорхойгүй	

Хүснэгт 3

д/д	Иргэний гүйцэтгэх үүрэг	Мэдээллийн агуулга буюу бүрдүүлэх баримт бичиг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
1	Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу “Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг авах шалгах өгөх” үүрэг	Хууль, санхүү, нягтлан бодох бүртгэл, аудит, бизнесийн удирдлагын мэргэжил эзэмшсэнийг нотлох баримт бичгийн хуулбар	Баримт бичгийг олшруулах	5
			Баримт бичгийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэх	15
		Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан болохыг тодорхойлох баримт бичиг	Нийгмийн даатгалын байгууллагаас лавлагаа авах	10
		Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалтад заасан сургалтанд хамрагдсан болохыг нотлох баримт бичиг	Сургалтанд хамрагдсан болохыг нотолж сургалт зохион байгуулсан байгууллагаас олгосон гэрчилгээ хуулбарлах	5
		Батлагдсан маягтын дагуу гаргасан өргөдөл	Өргөдлийн маягттай танилцаж, шаардлагатай мэдээллийг бэлтгэх	10
			Маягтын дагуу өргөдлийн маягтыг бөглөх	5

² Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 123 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нотариатын үйлчилгээний хөлс зардал”-ын Хоёрын 1-д зааснаар баримт бичгийн хуулбар гэрлэхэд нүүр тутмаас 500 төгрөг бөгөөд боловсролын диплом нь 4 нүүр бүхий байх тул иргэнээс шууд гарах зардлыг 2000 төгрөгөөр тооцов.

			Бөглөсөн маягтын алдааг нягтлах	5
		Шалгалтын хураамж төлсөн баримт	Банкинд хандаж холбогдох дансанд хураамжийг төлөх	15
			Хураамж төлсөн баримтыг өргөдлө хавсаргах	5
2	Нийт хугацаа			
3	Уг үүрэгтэй холбоотой иргэнээс шууд гарах мөнгөн зардал		Зардлын хэмжээ	
3.1.	Баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх зардал			
3.2.	Шалгалтын хураамж			

2.3.ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОЖ ГАРГАХ:

Энэ үе шатанд өмнөх хэсэгт дурдагдсан Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслөөр төлбөрийн чадваргүйдлийг тогтоох харилцаанд оролцогч хэрэг гүйцэтгэгч иргэнд шинээр бий болж байгаа үүргийг нийт хуулийн төслийн үйлчлэлд хамрагдах хэдэн иргэн, жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг тооцоолон гаргана.

Тоон үзүүлэлтийг **тохиолдлын тоо** буюу уг үүргийг хэдэн иргэн гүйцэтгэх ёстойг, **давтамжийн тоо** буюу дээрх иргэдэд жилд хэдэн удаа үүргийг давтан гүйцэтгэх ёстой вэ гэсэн үзүүлэлтээр тодорхойлно. Өөрөөр хэлбэл:

$$\text{ТООН ҮЗҮҮЛЭЛТ} = \text{ТОХИОЛДЛЫН ТОО} \times \text{ДАВТАМЖИЙН ТОО}$$

гэсэн томъёогоор гаргана. Үүнийг доорх хүснэгтээр үзүүлэв.

						Хүснэгт 4
д/д	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	х	Давтамжийн тоо	=	Тоон үзүүлэлт
1	Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалтад заасны дагуу “хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалтад хамрагдах” үүрэг	50	х	1 ³	=	50
2	Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу “Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг авах шалгалт өгөх” үүрэг	50	х	1 ⁴	=	50

Хуулийн төслөөр бий болгож байгаа үүргийг жилд хэдэн иргэн, хэдэн удаа биелүүлэх ёстой талаарх тохиолдлын тоо болон давтамжийг гаргахын тулд хуулийн төслийн үзэл баримтлал болон танилцуулга, холбогдох бусад судалгаатай танилцлаа.

³ Хэрэг гүйцэтгэгчийн бэлтгэх сургалтад тодорхой давтамжтай хамрагдах талаар заагаагүй тул жилд нэг удаа уг үүргийг хэрэгжүүлнэ гэж үзэж давтамжийг 1 байхаар тооцов.

⁴ Хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох шалгалтыг хувь хүн 1 удаа өгөх тул давтамжийг 1 байхаар тооцов.

Хуулийн төслийн үзэл баримтлалд “Манай улсад хэрэг гүйцэтгэгчийг тусгай сургалтад мэргэшүүлэн зөвшөөрөл олгож байсан бөгөөд сүүлийн жилүүдэд энэ ажиллагаа огт хийгдээгүй бөгөөд тухай үед зөвшөөрөл авсан цөөн тооны хэрэг гүйцэтгэгч ажиллаж байна. Тухайлбал сүүлийн 10 орчим жилд зөвхөн 5 хэрэг гүйцэтгэгч дампуурлын хэрэгт тус бүр 2-10 удаа оролцсон байна.”⁵ гэжээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалын дээрх хэсгээс тохиолдлын тоо буюу шалгалт өгөх, сургалтад хамрагдах иргэний тоог шууд хуулбарлан хэрэглэж болох боловч хуулийн төслийн шинэчилсэн найруулга нь энэ харилцаатай холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор зорьж байгаа бөгөөд энэ нь зах зээлийн харилцаа улам бүр нарийн төвөгтэй болж байгаа энэ үед цаашид “дампуурсан” гэсэн үндэслэлээр нэхэмжлэгчдийн эрх зөрчигддөг байдлыг бууруулахад чиглэгдэхээр заасан байна.

Иймд тохиолдлын тоог эрх зүйн орчин боловсронгуй болсноор төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цаашид нэмэгдэх магадлалтайгаас гадна Дампуурлын тухай хууль батлагдаж байсан цаг үетэй харилцуулахад манай улсын эдийн засгийн багтаамж өссөн зэргийг харгалзан хэрэг гүйцэтгэгчийн эрх горилогчийн тоог одоо байгаа хэрэг гүйцэтгэгчээс 10 дахин их байхаар тооцоолсон болно.

2.4.НИЙТ ДҮНГ ТООЦООЛЖ ГАРГАХ:

Энэ үе шатанд Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн хүрээнд иргэнд шинээр бий болсон үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэнд үүсэх ачааллыг **цаг хугацаагаар** тооцоолон гаргана. Иргэнд үүсэх ачаалал нь өмнөх үе шатуудад тооцоолон гаргасан нэг иргэний цаг хугацааны зарцуулалтыг тоон үзүүлэлтээр үржүүлснээр тодорхойлогдоно.

АЧААЛАЛ = ЦАГ ХУГАЦААНЫ ЗАРЦУУЛАЛТ Х ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 5

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙДЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР УГ ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭЛД ХАМРАГДАХ НИЙТ ИРГЭДЭД ҮҮСЭХ ЦАГ ХУГАЦААНЫ АЧААЛАЛ						
д/ д	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Х	Тоон үзүүлэлт		Нийт цаг хугацааны ачаалал
1	Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалтад заасны дагуу “хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалтад хамрагдах” үүрэг	60 мин	Х	50	=	3000 минут буюу 50 цагийн ачаалал нийт сургалтад хамрагдах иргэдэд үүсэх юм.
2	Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу “Хэрэг гүйцэтгэгчийн үйл	80 мин	Х	50	=	4000 минут буюу 66,6 цагийн ачаалал нийт шалгалт өгөх

⁵ Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалаас 4 дэх тал

	ажиллагаа эрхлэх эрхийг олгох шалгалт өгөх” үүрэг					иргэдэд үүсэх юм.
--	--	--	--	--	--	-------------------

Одоо харин иргэнд бодитоор буюу шууд нэрлэн заасан мөнгөн хэлбэрээр үүсэх зардал буюу нэмэлт зардлыг хуулийн төслийн үйлчлэлд хамаарах иргэдэд үүсэх нийт дүнгээр тооцоолох юм. Үүнийг нэрлэгдсэн мөнгөн дүн буюу нэмэлт зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлэх замаар тооцон гаргана.

Хүснэгт 6

д/д	Иргэний гүйцэтгэх үүрэг	Тухайн үүргийн хүрээнд үүсэх мөнгөн зөрдлын төрөл	Мөнгөн зөрдлын хэмжээ	х	Тоон үзүүлэлт	=	Нийт нэмэлт зардал
1	Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалтад заасны дагуу “хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалтад хамрагдах” үүрэг	Баримт бичиг нотариатаар гэрчлүүлэх зардал	2000	х	50	=	100.000 төгрөг
		Сургалтад хамрагдах төлбөр	Тодорхой бус	х	50	=	
2	Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу “Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгох шалгалт өгөх” үүрэг	Баримт бичиг нотариатаар гэрчлүүлэх зардал	2000	х	50	=	100.000 төгрөг
		Шалгалтын хураамжийн төлбөр	Тодорхой бус	х	50	=	

2.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙГ ШАЛГАХ НЬ:

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн дагуу иргэнд дараах хоёр төрлийн үүрэг шинээр бий болохоор тусгагдсан байна. Үүнд:

- Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн **27.2.2 дахь заалтад заасны дагуу “хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалтад хамрагдах” үүрэг;**
- Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу **“Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгох шалгалт өгөх” үүрэг.**

Иргэнд үүсэх зардлын тооцооны онцлог нь тухайн үүргийг хэрэгжүүлэхийн тулд иргэний зарцуулах цаг хугацааг тооцоолон гаргадаг ба уг цаг хугацааг мөнгөн дүнгээр илэрхийлдэггүй явдал юм.

Энэ нь иргэн бүрийн хувьд цаг хугацаа нь харилцан адилгүй үнэ цэнэтэй байдагтай холбоотойгоор мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй гэж үздэг болно.

Харин иргэн бүрээс ижил хэмжээгээр гарахаар шууд нэрлэн заасан мөнгөн хэлбэрийн зардлыг “нэмэлт зардал” гэсэн томьёололд багтааж, тэдгээрийн дүнг тооцоолдог болно.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн хуулийн төслөөр иргэнд үүсэж байгаа “хэрэг гүйцэтгэгчийн сургалтад хамрагдсан байх” үүрэг нь 1 иргэн уг үүргийг гүйцэтгэхэд 60 минутын цаг хугацааны ачаалал үүсгэхээр байгаа бол хуулийн төслийн үйлчлэлд хамрагдах нийт иргэдийн хувьд 50 цагийн ачаалал үүсгэхээр байна. Энэ үүргийг дагалдан нэмэлт мөнгөн зардалд баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэхэд 2.000 төгрөг, сургалтад хамрагдах тогтоосон төлбөр гэсэн хоёр төрлийн зардал гарахаар байна.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн хуулийн төслөөр иргэнд үүсэж байгаа дараагийн “хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт өгөх” үүрэг нь 1 иргэн уг үүргийг гүйцэтгэхэд 80 минутын цаг хугацааны ачаалал үүсгэхээр байгаа бол хуулийн төслийн үйлчлэлд хамрагдах нийт иргэдийн хувьд 66,6 цагийн ачаалал үүсгэхээр байна. Энэ үүргийг дагалдан нэмэлт мөнгөн зардалд баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэхэд 2.000 төгрөг, шалгалт өгөх бүртгэлийн хураамжийн төлбөр гэсэн хоёр төрлийн зардал гарахаар байна.

Хуулийн төсөл иргэнд хүлээлгэж буй үүргийг хэрэгжүүлэхийн тулд гарах зардал нь хуулийн төслөөр бий болох үр өгөөжтэй харьцуулахад байж болох хэмжээнд буюу зардал бага үр өгөөж өндөртэй байна.

ГУРАВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг судалж үзэхэд төрийн байгууллагад зардал үүсгэх зохицуулалт тусгагдсан байх тул хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцоолохдоо аргачлалд заасны дагуу доорх дарааллыг баримтлан гүйцэтгэх юм. Үүнд:

- Төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа байгаа чиг үүргийг тогтоох;

- Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- Гарах зардлыг тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

3.1.ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРГИЙГ ТОГТООХ НЬ:

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 29.2-т заасан журмын дагуу олгоно.” гэж заасан байна. Энэ зохицуулалтаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт зохион байгуулах чиг үүргийг оногдуулсан байна.

Мөн хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.2-т “хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалтад хамрагдсан байх” үүргийг иргэнд оногдуулснаас үзэхэд төрийн аль нэг байгууллага уг сургалтыг зохион байгуулах чиг үүргийг хүлээхээр ойлгогдож байна. Хуулийн төсөлд энэ чиг үүргийг аль байгууллага хүлээх талаар тодорхой заагаагүй боловч хуулийн төслийн бусад зохицуулалттай уялдуулан уг чиг үүргийг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.1, 21 дүгээр зүйлийн 21.5 24.1, 96.1, 97.1, 114.3 дахь хэсгүүдэд Дампуурлын тухай хуульд байхгүй “олон нийтэд мэдээллэх” үүргийг шүүхэд оногдуулсан байна.

Иймд хуулийн төслийн дагуу төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоог дээрх хоёр байгууллага буюу Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон шүүхэд шинээр нэмэгдэж байгаа чиг үүргээр хязгаарлан уг үүргийг хэрэгжүүлэхэд тухайн байгууллагад үүсэх хүний нөөцийн ачааллаар дамжуулан зардлыг тооцоолох юм.

3.1.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл батлагдан гарснаар дараах үүргийг шинээр хэрэгжүүлэх байна. Үүнд:

- Төлбөрийн чадваргүйдлийн хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт зохион байгуулах /хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт зааснаар/
- Төлбөрийн чадваргүйдлийн хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалт зохион байгуулах /хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалтад зааснаар/

3.1.2.Шүүх нь Дампуурлын тухай хуульд зааснаас гадна дараах зүйл, хэсэг, заалтын дагуу холбогдох мэдээллийг олон нийтэд мэдээллэх үүргийг хүлээсэн байна. Үүнд:

- Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны талаар нийтэд мэдээллэхээр заасан энэ хуульд заасан мэдээллийг шүүхийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд 2-оос доошгүй хоногийн хугацаанд нийтэлнэ. /хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг/
- Түр хэрэг гүйцэтгэгчийг томилсон, хариуцагчид хөрөнгөө захиран зарцуулахгүй байхыг даалгасан шүүгчийн захирамжийн талаар нийтэд мэдээлж, үүрэг гүйцэтгэгч, түүнд өртэй этгээд, түр хэрэг гүйцэтгэгчид гардуулна. /хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг/

- Шүүгч нь хариуцагчийн хөрөнгө захиран зарцуулахгүй байхыг даалгасан захирамжаа хүчингүй болгосон бол энэ тухай нийтэд мэдээлнэ. /хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг/
- Энэ хуулийн 94, 95 дугаар зүйлд заасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох хүсэлтийн талаар шүүх нийтэд мэдээлнэ. /хуулийн төслийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг/
- Энэ хуулийн 93, 94, 95 дугаар зүйлд заасны дагуу гарсан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох тухай шүүхийн шийдвэр болон зогсоох болсон үндэслэлийн талаар нийтэд мэдээлнэ. /хуулийн төслийн 97 дугаар зүйлийн 97.1 дэх хэсэг/
- Энэ хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу дахин зохион байгууллах ажиллагаа дуусгавар болсон бол шүүх энэ тухай шийдвэрээ нийтэд мэдээлж, хэрэг гүйцэтгэгч, хариуцагч, шаардлага гаргасан нэхэмжлэгчдэд гардуулна. /хуулийн төслийн 114 дүгээр зүйлийн 114.3 дахь хэсэг/

Шүүхэд шинээр үүсч байгаа чиг үүргийг онцлог нь дээр дурдсан үүргүүд нь бүгд “нийтэд мэдээллэх” гэсэн ижил утгатай бөгөөд “нийтэд мэдээллэх” гэдгийг хэрхэн хэрэгжүүлэхийг хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан байна.

Дээрх чиг үүргийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон шүүхэд хүлээлгэснээр уг байгууллагад ямар хэмжээний хүний нөөц шаардлагатай болохыг үргэлжлүүлэн тооцно.

3.2.ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ:

Шаардлагатай хүний нөөцийг 3.1 дэх хэсэгт тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд төрийн байгууллагаас хийх ажил үйлчилгээнд зарцуулах хугацаа болон уг ажил үйлчилгээг нэг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо /тохиолдлын тоо/-ны үржвэрээр тооцоолон гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо төрийн байгууллагын адил төстэй өөр бусад чиг үүргийг судлах, аргачлалд заасан стандарт үйл ажиллагаанд ердийн дундаж албан хаагчийн зарцуулах хугацаа зэргийг харгалзан замаар тогтоолоо.

3.2.1.ХУУЛЬ ЗҮЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙ ХЭРЭГЦЭЭ:

3.2.1.а.Төлбөрийн чадваргүйдлийн хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт зохион байгуулахтай холбоотойгоор хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үүсэх хүний нөөцийн хэрэгцээ:

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		

Төлбөрийн чадваргүйдлийн хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт зохион байгуулах	Шалгалт зохион байгуулах тов тогтоох	8 цаг	1 ⁶	8 цаг
	Шалгалт зохион байгуулах зар мэдээлэл түгээх	4 цаг	1	4 цаг
	Шалгалтад оролцох оролцогчдыг бүртгэх	0,5 цаг	50 ⁷	25 цаг
	Шалгалтын даалгавар бэлтгэх	40 цаг	1	40 цаг
	Шалгалтын зохион байгуулах байр, техник хэрэгслийг бэлтгэх	24 цаг	1	24 цаг
	Шалгалтыг зохион байгуулах	8 цаг	1	8 цаг
	Шалгалтыг дүгнэх	16 цаг	1	16 цаг
	Дүнг оролцогчдод мэдээлэх	2 цаг	1	2 цаг
	Шалгалттай холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх	24 цаг	1	24 цаг
	Шалгалтад амжилттай оролцсон этгээдэд батламж олгох	8 цаг	1	8 цаг
	Шалгалтад тэнцэж эрх авсан этгээдийг мэдээллийн санд бүртгэх	0,2 цаг	50 ⁸	10 цаг
	Хэрэг гүйцэтгэгчийн эрх авсан этгээдийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагад илгээх	4 цаг	1	4 цаг
	Шалгалттай холбоотой тайлан мэдээ бэлтгэх	16 цаг	1	16 цаг
	Шалгалтын материалыг холбогдох журмын дагуу архивлах	20 цаг	1	20 цаг
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА				209 цаг

⁶ Эрх олгох шалгалтын давтамжийг хуулийн төсөлд заагаагүй бөгөөд жилд 2-оос дээш удаа авах талаар дурдаагүй болно. Иймд зардлын тооцоог “нэг жил” үүсэх зардлаар тооцоолдог тул тохиолдлын тоог 1 удаа шалгалт зохион байгуулахаар тооцов.

⁷ Иргэнд үүсэх зардлын тооцоо хэсэгт 50 иргэн уг шалгалтад оролцох магадлалтай гэж тооцсон тул тохиолдлын тоог уг тоогоор тооцсон болно.

⁸ Шалгалтад оролцсон нийт оролцогчдыг мэдээллийн санд мэдээлэл оруулах шаардлагатай.

$$\text{ШААРДЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦ} = 209 \text{ цаг}^9 : 8 \text{ цаг}^{10} = 26,2 \text{ өдөр}^{11} : 200 \text{ өдөр}^{12} = 0,13 \text{ хүн шаардлагатай}$$

3.2.1.6.Төлбөрийн чадваргүйдлийн хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалт зохион байгуулах чиг үүргийн хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		
Төлбөрийн чадваргүйдлийн хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалт зохион байгуулах	Сургалтын товыг тогтоох	16 цаг	1	16 цаг
	Сургалтын талаарх мэдээллийг мэдээллийн хэрэгслээр түгээх	16 цаг	1	16 цаг
	Сургалтад хамрагдах хүсэлтэй этгээдийг бүртгэх	0,5 цаг	50	25 цаг
	Сургалтын төлөвлөгөө гаргах	8 цаг	1	8 цаг
	Сургалтын хөтөлбөрийн агуулгыг гаргах	24 цаг	1	24 цаг
	Сургалтад хичээл заах сургагчтай гэрээ байгуулах	8 цаг	3 ¹³	24 цаг
	Сургагчийн бэлтгэсэн хичээлийн агуулгыг хянаж батлах	16 цаг	3	48 цаг
	Сургалт зохион байгуулах байр, техник хэрэгслийг бэлтгэх	16 цаг	1	16 цаг
	Сургалтыг зохион байгуулах	16 цаг	1	16 цаг
	Сургалтад оролцогчдын хамрагдсан байдлыг үнэлэх	8 цаг	1	8 цаг
	Сургалтад хамрагдсан этгээдүүдэд батламж олгох	0,5 цаг	50	25 цаг

⁹ Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт хугацаа

¹⁰ Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг өдөрт ажиллах цаг

¹¹ Чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай цагийг ажлын өдөрт шилжүүлсэн тоо.

¹² Нэг жилд ойролцоогоор 261 ажлын өдөр байдаг бөгөөд аргачлалд зааснаар үүнээс нийтээр амрах баярын өдөр хуулиар эдлэх ээлжийн амралтын хугацаа, болзошгүй чөлөө авах магадлалтай өдөр зэргийг хасаж нэг жилд хүн идэвхтэй ажиллах өдөр нь 200 хоног байхаар заасан болно.

¹³ Нэг удаагийн сургалтад 3-аас багагүй тооны багш хичээл орох магадлалтай гэж үзэж тооцсон.

Сургалтад хамрагдсан талаар цахим мэдээллийн санд мэдээлэл оруулах	0,2 цаг	50	10 цаг
Сургалтын талаар тайлан мэдээлэл бэлтгэх	16 цаг	1	16 цаг
Сургалттай холбоотой материалыг архивлах	16 цаг	1	16 цаг
НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА			268 цаг
ШААРДЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦ = 268 цаг¹⁴ : 8 цаг¹⁵ = 33,5 өдөр¹⁶ : 200 өдөр¹⁷ = 0,17 хүн шаардлагатай			

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслөөр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэмэгдэх буюу хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг нэгтгэн үзүүлбэл:

д/д	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Шаардлагатай хүний нөөц
1	Төлбөрийн чадваргүйдлийн хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт зохион байгуулах /хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт зааснаар/	0,13 хүн
2	Төлбөрийн чадваргүйдлийн хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалт зохион байгуулах /хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалтад зааснаар/	0,17 хүн
3	НИЙТ	0,3 хүн

3.2.2.ШҮҮХЭД ҮҮСЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭ:

Энэхүү зардлын тооцооны 3.1.2 дахь хэсэгт зааснаар шүүх нь 5 төрлийн шийдвэрийн талаар олон нийтэд мэдээллэх заасан байна. Иймд хүний нөөцийг тооцохдоо уг чиг үүргийг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагаа болон зарцуулах цаг хугацааг ижил байхаар тооцоолж, тохиолдлын тоог тухайн шийдвэр тус бүрт өөр байхаар тооцоолох нь зүйтэй байна.

¹⁴ Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт хугацаа

¹⁵ Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг өдөрт ажиллах цаг

¹⁶ Чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай цагийг ажлын өдөрт шилжүүлсэн тоо.

¹⁷ Нэг жилд ойролцоогоор 261 ажлын өдөр байдаг бөгөөд аргачлалд зааснаар үүнээс нийтээр амрах баярын өдөр хуулиар эдлэх ээлжийн амралтын хугацаа, болзошгүй чөлөө авах магадлалтай өдөр зэргийг хасч нэг жил хүн идэвхтэй ажиллах өдөр нь 200 хоног байхаар заасан болно.

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
		минутаар
Хуулийн төслийн 21.5, 24.1, 96.1, 97.1, 114.3 дахь хэсэгт заасан шийдвэрийн талаар хуулийн төслийн 10.1 дэх хэсэгт зааснаар нийтэд мэдээлэх.	Хуульд заасан холбогдох шийдвэрийн цаасан болон цахим эхийг шүүхийн олон нийттэй харилцан албан хаагчид шилжүүлэх	10 мин
	Шүүхийн олон нийттэй харилцах ажилтан шийдвэрийг шүүхийн албан ёсны цахим хуудаст байршуулах	30 мин
	Шүүхийн шийдвэрийг өдөр тутмын хэвлэлд нийтлүүлэхээр захиалга өгөх	40 мин
	Өдөр тутмын хэвлэлд тавигдах мэдээллийн эхийг бэлтгэх, хянуулах	40 мин
	Өдөр тутмын хэвлэлд нийтүүлэх төлбөрийг төлөх	30 мин
	Төлбөрийн чадваргүйдлийн хэргийн оролцогчдод шийдвэрийг гардуулахаар мэдэгдэх	1 хүнд 10 минут Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд ¹⁸ дурснаар 39 дампуурлын хэрэгт 95 нэхэмжлэгч оролцсон талаар дурдсан бөгөөд энэ нь 1 хэрэгт ойролцоогоор 2,5 буюу 3 нэхэмжлэгчтэй, 1 хариуцагч, 1 хэрэг гүйцэтгэгч, 1 хариуцагчид төлбөртэй этгээдтэй гэж үзвэл дундажаар 6 этгээдэд шийдвэрийн талаар мэдэгдэж гардуулахаар байна. 60 минут
	Төлбөрийн чадваргүйдлийн хэргийн оролцогчдод шийдвэрийг гардуулах	1 хүнд 20 минут нийт 120 минут
	НИЙТ ХУГАЦАА	310 минут

¹⁸ Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын 3 дахь тал

д/д/	Хуулийн төсөлд тусгагдсан чиг үүрэг	Тохиолдлын тоо	Нэг тохиолдолд зарцуулах хугацаа	Нийт шаардлагатай хугацаа
1	Түр хэрэг гүйцэтгэгчийг томилсон, хариуцагчид хөрөнгөө захиран зарцуулахгүй байхыг даалгасан шүүгчийн захирамжийн талаар нийтэд мэдээлж, үүрэг гүйцэтгэгч, түүнд өртэй этгээд, түр хэрэг гүйцэтгэгчид гардуулна. /хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг/	20 ¹⁹	310 минут	6200 минут
2	Шүүгч нь хариуцагчийн хөрөнгө захиран зарцуулахгүй байхыг даалгасан захирамжаа хүчингүй болгосон бол энэ тухай нийтэд мэдээлнэ. /хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг/	20	150 минут ²⁰	3000 минут
3	Энэ хуулийн 94, 95 дугаар зүйлд заасан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох хүсэлтийн талаар шүүх нийтэд мэдээлнэ. /хуулийн төслийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг/	20	150 минут	3000 минут
4	Энэ хуулийн 93, 94, 95 дугаар зүйлд заасны дагуу гарсан төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох тухай шүүхийн шийдвэр болон зогсоох болсон үндэслэлийн талаар нийтэд мэдээлнэ.	20	150 минут	3000 минут

¹⁹ Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд дурдснаар 2004-2016 оны эхний хагасын байдлаар шүүх 174 дампууралтай холбоотой хэргийг шийдвэрлэсэн талаар дурдсан байна. Иймээс жилд дундажаар 15 дампуурлын хэргийг шийдвэрлэсэн байх ба энэ тоо цаашид өсөх хандлагатай тул тохиолдлыг тоог 20 байхаар тооцоолов.

²⁰ Энэ тухай зөвхөн нийтэд мэдээллэхээр заасан тул хэргийн оролцогчдод гардуулах талаар хийгдэх хугацааг оруулаагүй болно.

	/хуулийн төслийн 97 дугаар зүйлийн 97.1 дэх хэсэг/			
5	Энэ хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу дахин зохион байгууллах ажиллагаа дуусгавар болсон бол шүүх энэ тухай шийдвэрээ нийтэд мэдээлж, хэрэг гүйцэтгэгч, хариуцагч, шаардлага гаргасан нэхэмжлэгчдэд гардуулна. /хуулийн төслийн 114 дүгээр зүйлийн 114.3 дахь хэсэг/	20	310 миунт	6200 минут
6	НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА			21.400 минут буюу 357,6 цаг

ШААРДЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦ = 357,5 цаг²¹ : 8 цаг²² = 44,6 өдөр²³ : 200 өдөр²⁴ = 0,2 хүн шаардлагатай

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслөөр шүүхийн хүлээж байгаа олон нийтэд мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд энэ нь шүүхэд 357,5 цагийн ачаалал үүсгэж байгаа буюу 0,2 хүний нөөц шаардлагатай талаар тооцоо гарлаа. Энэ нь уг чиг үүрэгтэй холбоотойгоор орон тоо нэмэх шаардлагагүй бөгөөд одоо байгаа орон тоондоо багтаан хуулийн төслөөр бий болж байгаа үүргийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.

3.3.ГАРАХ ЗАРДЛЫГ ТООЦООЛОХ нь:

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн улсын төсөвт үүсэх төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалд заасны дагуу

- Хүний нөөцийн зардал²⁵
- Материаллаг зардал²⁶
- Бусад зардал²⁷ гэсэн зардлын төрлүүдийг нэгтгэн тооцоолон гаргах юм.

²¹ Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт хугацаа

²² Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг өдөрт ажиллах цаг

²³ Чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай цагийг ажлын өдөрт шилжүүлсэн тоо.

²⁴ Нэг жилд ойролцоогоор 261 ажлын өдөр байдаг бөгөөд аргачлалд зааснаар үүнээс нийтээр амрах баярын өдөр хуулиар эдлэх ээлжийн амралтын хугацаа, болзошгүй чөлөө авах магадлалтай өдөр зэргийг хасаж нэг жилд хүн идэвхтэй ажиллах өдөр нь 200 хоног байхаар заасан болно.

²⁵ Хүний нөөцийн зардал гэдэгт тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох цалин хөлс, бусад нэмэгдэл, тусламж, төрөөс албан хаагчдаа зориулан даадаг хүний нөөцтэй холбоотой гаргасан зардлыг нэг албан хаагчид оногдох хэмжээгээр тооцоолсныг ойлгоно.

²⁶ Материаллаг зардал гэдэгт тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг ойлгоно. Цахилгаан дулаан, бичиг хэрэг, урсгал засвар, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын гэх мэт

²⁷ Бусад зардал гэдэгт тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах шууд зардлыг ойлгоно.

3.3.1.Хүний нөөцийн зардал гэдэгт нэмэгдэж буй хүний нөөцөд олгох цалин хөлсийг ойлгоно.

Өмнөх үе шатанд тогтоосны дагуу хуулийн төслөөр бий болгож буй чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 0,3 орон тоотой, шүүхэд 0,2 орон тоо шаардлагатай гэдгийг тогтоосон болно. Энэ нь хүн нэмэх шаардлагагүй тул хүний нөөцийн болн материаллаг зардал хуулийн төслийн дагуу төрийн байгууллагад үүсэхгүй гэсэн үг юм.

3.3.2.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн хүрээнд дараах “нэмэлт зардал” улсын төсөвт үүсэхээр байна. Үүнд:

д/д	Нэмэлт зардал
1	Хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалт болон эрх олгох зохион байгуулахтай холбоотой зардал үүсэх боловч уг нэмэлт зардлыг сургалтад хамрагдах, шалгалт өгөх этгээдүүдийн сургалтын хураамжаар санхүүжүүлэн шийдвэрлэх боломжтой.
2	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрх авсан хэрэг гүйцэтгэгчдийн талаарх цахим мэдээллийн сантай байхаар хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт заасан тул уг санг бий болгохтой холбоотой зардал нэг удаа улсын төсөвт үүснэ.
3	Шүүх нь хуулийн төслийн дагуу холбогдох шийдвэрийг өдөр тутмын сонинд нийтлүүлэх төлбөр гарах юм.

3.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙГ СУДЛАХ нь:

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг судалж үзэхэд уг харилцаатай холбоотойгоор шинэ үүрэг хүлээж байгаа төрийн байгууллага нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон шүүх байна.

Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төлбөрийн чадваргүйдлийн хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт зохион байгуулах болон хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх сургалт зохион байгуулах чиг үүргийг оногдуулсан байна. Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрд үүсэх зардлыг уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тооцоолон, түүгээр дамжуулан материаллаг зардлыг гаргалаа.

Шүүх нь хуулийн төслийн дагуу хэд хэдэн төрлийн шийдвэрийн талаар нийтэд мэдээллэх болон хэргийн оролцогчдод гардуулах үүрэг хүлээж байгаа бөгөөд уг үүргийг хэрэгжүүлэхэд шүүхэд тодорхой хэмжээний хүн хүч нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд тухайн нэмэгдэх хүний нөөцийг дагалдан материаллаг зардал гарах юм.

Улсын төсөвт шууд ачаалал болж ирэх бусад зардлыг “нэмэлт зардал” хэсэгт гаргасан болно. Нэмэлт зардлын тухайд сургалт, шалгалт зохион байгуулахтай холбоотой зардал үүсэх боломжтой боловч үүнийг сургалт, шалгалтад хамрагдахыг хүсэж өргөдөл гаргасан этгээдийн хураамжаар шийдвэрлэх боломжтой байна.

Гагцхүү цахим мэдээллийн сан бий болгохтой холбоотой зардал нэг удаа үүсэхээр байна.

Хэдийгээр хуулийн төсөл нь улсын төсөвт үүсэх зардал багатай байгаа боловч сургалт зохион байгуулахтай холбоотой чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжтой юм. Энэ нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ачааллыг бууруулахын зэрэгцээ мэргэжлийн байгууллагад хариуцуулах нь сургалтын чанарыг дээшлүүлэх юм.

Иймд Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөлд тусгагдсан зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бол Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.” гэж заасанд нийцүүлэн энэ талаарх заалтыг хуулийн төсөлд тусгах боломжтой юм.

-----oOo-----